

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын
даргын 2017 оны 05 дугаар сарын 24-ний
өдрийн 11/18 дугаар тушаалын хавсралт



Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын
хүний нөөцийг хөгжүүлэх стратеги,
түүний хэрэгжилтийг хянах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол улсын Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги, Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр, Засгийн газар болон Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрүүд, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг, ГБХЗХГ-ын хэтийн бодлого, шийдвэр зэргийг үндэслэн байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх стратеги, түүний хэрэгжилтийг хянах журмыг байгууллагын албан хаагчдын санал хүсэлтийг тусган боловсруулав.
- 1.2. Хүний нөөц нь байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд албан хаагчдын мэдлэг, ур чадвар, туршлагыг үр ашигтай, үр нөлөөтэй ашиглах албан ёсны зохион байгуулалттай үйл ажиллагаа юм.
- 1.3 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний ажилтнуудын хүний нөөцийг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах, түүний хэрэгжүүлэх үйл ажиллагаанд энэхүү стратегийг, журмыг мөрдлөг болгоно.
- 1.4. Энэхүү стратегийг, журмын салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь байгууллагын “Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар олгох хөтөлбөр” болно.

Хоёр. Хүний нөөцийг хөгжүүлэхэд баримтлах зарчим

- 2.1. Хүний нөөцийг хөгжүүлэхэд баримтлах үндсэн зарчим нь тухайн ажилтныг албан тушаалд томилох, дэвшүүлэхэд төрийн албанд мэргэшсэн байдал, тогтвор суурьшлыг харгалзан үзэх
- 2.2. Албан тушаалд нээлттэй, шударга өрсөлдөөний зарчмаар холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж ажиллуулах
- 2.3. Тус газар нь харьяа хүүхдийн парк, хүүхдийн зусланд хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх, сургах, мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого баримтлах

2.4. Тус газар нь аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс гаргасан удирдамж, чиглэл, зөвлөмжийг үндэслэн байгууллагын хүний нөөцийн стратегийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгтгэн дүгнэх, ерөнхий чиг удирдлагаар хангах үүрэг хүлээх

Гурав. Стратеги, журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.1. Зорилго: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэшсэн боловсон хүчнээр хангах, хүний нөөцийн удирдлагын арга барил, манлайллыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

3.2. Зорилтууд:

3.2.1. Хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, албан тушаалд томилох, дэвшүүлэх ажлыг оновчтой зохион

3.2.2. Хүний нөөцийг хөгжүүлж, тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх

3.2.3. Хүний нөөцийн удирдлагын арга барилыг боловсронгуй болгож, удирдлагын манлайлах чадварыг хөгжүүлэх

Дөрөв. Стратеги, журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.1. Хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, албан тушаалд томилох, дэвшүүлэх ажлыг оновчтой зохион байгуулах зорилтын хүрээнд:

4.1.1. Байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардлагатай төсөв санхүү, цалин урамшууллын зардлын тооцоо гаргаж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх

4.1.2. Тус газрын хэмжээнд шаардлагатай байгаа мэргэжилтэй боловсон хүчний судалгааг жил бүр гаргаж, зайлшгүй шаардлагатай боловсон хүчнийг байгууллагад ирж ажиллах талаар санал хүргүүлэх

4.1.3. Шаардлагатай боловсон хүчнийг төрийн албаны мэргэшлийн шалгалтад бэлтгэлийг хангаж оролцуулах талаар арга хэмжээ авах

4.1.4. Тус газрын хэмжээнд хэрэгцээтэй байгаа мэргэжил, сул ажлын байрны талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, шаардлагатай бол энэ талаар зарлан мэдээлэх

4.1.5. Ерөнхий боловсролын боловсролын сургуулийг төгсөгчдөд байгууллагын үндсэн чиг үүрэг, ажил, мэргэжлийн онцлогийг танилцуулж, тэдэнд орон нутагт

шаардлагатай байгаа гэр бүл, хүүхэд, залуучуудын мэргэжлийн чиглэлээр суралцах талаар сурталчилгаа явуулах

4.1.6. Тус газрын хүний нөөцийг төлөвлөж хэрэгжүүлэх ажилд жендерийн тэгш байдлыг хангах асуудлыг харгалзан үзэх

4. 2. Хүний нөөцийг хөгжүүлж, тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

4.2.1. Тус газрын ажилтнуудыг хөгжүүлэх, сургаж мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах арга хэмжээний талаар газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх

4.2.2. Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж, хүний нөөцийн бодлого хариуцсан ажилтанг томилон ажиллуулах

4.2.3. Газрын ажилтнуудыг хяналт үнэлгээ, бодлогын дүн шинжилгээ хийх, удирдлагын манлайлал, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил хамгаалал, судалгааны арга зүйн чиглэлээр сургалтанд хамруулж мэргэшүүлэх

4.2.4. Албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, орон байраар хангах, шагнал урамшуулал, нөхөн олговор олгох, тусламж дэмжлэг үзүүлэх асуудлуудыг хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын дотоод журмаар зохицуулах хэрэгжүүлэх

4.2.6. Байгууллагад тогтвор суурьшилтай, үр дүнтэй ажиллаж байгаа албан хаагчдыг цаашид суралцах, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, ялангуяа мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулахад урамшууллын арга хэмжээ авч хэрэгжүүлэх

4.2.7. Аймгийн оюутны холбооны санаачилга, үйл ажиллагааг дэмжиж, орон нутагт зайлшгүй шаардлагатай гэр бүл судлаач чиглэлээр гэрээ байгуулан хамтран ажиллах

4.2.8. Хүний нөөцийг хөгжүүлэхэд шаардагдах зардлыг тухайн жилийн байгууллагын төсөвт тусган санхүүжилтыг шийдвэрлэх

4. 3. Хүний нөөцийн удирдлагын арга барилыг боловсронгуй болгож, удирдлагын манлайлах чадварыг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

4.3.1. Байгууллага болон албадыг удирдах, манлайлах, зөрчлийн болон эрсдлийн менежментийг тооцох зэрэг сургалтад хамруулж, манлайллын чадавхийг дээшлүүлэх

4.3.2. Байгууллагын удирдлагыг нээлттэй, өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулж, удирдан зохион байгуулах, манлайлах ур чадварыг харгалзан томилох

4.3.3. Байгууллагын хүний нөөцийн удирдлагад мэдээллийн технологийг ашиглаж сурах

4.3.4. Удирдах ажилтнуудын ажлыг байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх талаар хэрэгжүүлсэн ажлын үр дүнтэй нь холбон дүгнэж, урамшуулал хариуцлага тооцох

Тав. Стратеги, журмын удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

5.1. Удирдлага, зохион байгуулалт :

5.1.1. Газрын хэмжээнд хүний нөөцийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг жилийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн бодлого, удирдлагаар хангах, зохицуулах үүргийг газрын дарга, харьяа байгууллагын нэгжийн менежрүүд хүлээнэ.

5.1.2 Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэхэд олон улсын болон иргэний нийгмийн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хамтран ажиллана.

5.1.3. Газар нь энэхүү стратеги, журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүр тооцож, байгууллагын төсөвт тусгана.

5.1.4. Байгууллагын хүний нөөц хариуцсан ажилтан нь энэхүү стратеги, журмыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр гарган батлуулна.

5.1.5. Стратеги, журмын хэрэгжилтэнд байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн жил бүр үнэлгээ хийж, үр дүнг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэн, дүгнэлт өгч ажиллана.

5.2. Стратеги, журмын санхүүжилт :

5.2.1. Газрын жилийн төсөв, өөрийн орлого

5.2.2. Олон улсын болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн тусламж, хандив, дэмжлэг

Зургаа. Хүрэх үр дүн

6.1. Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлт, боловсон хүчнийг сонгох, хуваарилах, нөөц бүрдүүлэх ажлын зохион байгуулалт оновчтой болж, төрийн албаны мэргэшсэн тогтвортой байх зарчим хэрэгжинэ.

6.2. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, тогтвор суурьшил сайжирч, гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо төлөвшинэ.

6.3. Төрийн албан хаагчдирдах албан тушаалтнуудын манлайлах ур чадвар дээшилж, хүний нөөцийн удирдлагын арга хэлбэр, зохицуулалтын механизм боловсронгуй болно.

7. Стратеги журмыг хэрэгжүүлэх хугацаа: 2017-2020

ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР